

ГАН ХИЙЦ ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН

ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

Улаанбаатар хот

2018.04.06

Ган хийц ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн 2017 оны ээлжит хурлыг 2018 оны 04 дүгээр сарын 06-ны өдрийн 11:00 минут компанийн ТУЗ-ийн даргын өрөөнд хийв.

Хуралд: Хувьцаа эзэмшигч М.Даваасүрэн, Хасвуу ХХК-ийг төлөөлж Энхмэнд, Л.Чинбат, Ганболд, Лувсандорж, Болдбаатар, Би ди сек ҮЦК-тай Б.Тэмүүлэн нар оролцлоо.

Төлөөлөн удирдах зөвлөлийн Хараат бус гишүүн Д.Нямжав, Хараат гишүүн Э.Долгорсүрэн, Б.Ганбат, Б.Эрдэнэбаяр, Д.Оюунзул нар оролцов.

Хуралд тус компанийн хувьцаа эзэмшигчдийн 91,37% буюу 221555 ширхэг хувьцаа эзэмшигч хүрэлцэн ирсэн тул Компанийн тухай хуулийн дагуу хурлын ирц бүрдсэн гэж үзээд хурлыг эхлэв.

Хурлын даргаар Хувьцаа эзэмшигч М.Даваасүрэн, нарийн бичгийн даргаар Б.Эрдэнэбаяр нарыг сонгож батлав.

Хурлын дарга хурлаар хэлэлцэх асуудал, хурлын дотоод журмыг тус тус танилцуулж, батлуулав. Хурлыг 11:24 минут эхэлж, 12:30 цагт дуусгахыг санал оруулж батлууллаа.

Бүх хэлэлцэх асуудлаа танилцуулж дуусаад санал хүсэлтээ хэлэх санал оруулж байна. /Хуралд оролцсон бүх гишүүд 100 хувь саналаар зөвшөөрөв. /Та бүхэнд хурлын материалыг хүргүүлсэн. Танилцсан байх гэж бодож байна.

Хэлэлцэх асуудал:

1. Компанийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэх
2. ТУЗ-ийн 2018 оны зардлын төсөв, Компанийн 2018 оны захиргаа, үйлчилгээний зардлын төсвийг батлах
3. Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнийг нөхөн сонгох

Хэлэлцсэн нь:

Хэлэлцэх асуудлын дараалалын дагуу **ТУЗ-ийн хийсэн ажлын тайлан болон компанийн үйл ажиллагааны талаарх** мэдээллийг ТУЗ-ийн дарга М.Даваасүрэн танилцуулав. Тайлан дараах чиглэлээр тайланг танилцуулав.

1. Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны тайлан
 - Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүн
 - ТУЗ, дэргэдэх хороодын талаарх мэдээлэл
 - Ногдол ашиг
2. Ган хийц ХК-ийн үйл ажиллагааны мэдээлэл

- Танилцуулга
- Удирдлагын бүтэц бүрэлдэхүүн
- Компанийн үйл ажиллагааны төлөвлөгөө түүний хэрэгжилт
- 2017 оны улсад төлсөн татвар
- ТУЗ-ийн болон ЗАА-н 2017 оны төсвийн гүйцэтгэл
- 2017 оны бүтээн байгуулалтууд
- Цаашид анхаарах ажлууд

Төмөр хийц үйлдвэрлэл, барилга угсралт 1,6 тэрбум төгрөгийн борлуулалтын орлоготой ажилласан байна. 2017 онд 102 сая төгрөгийн татварын Улсын төсөвт төвлөрүүлсэн.

Мөн Гүйцэтгэх захирлаар Ц.Батбаяр нь өөрийн хүсэлтийн дагуу Канад явах болсон тул ажлаасаа чөлөөлөгдсөн. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн П.Төвсанаа нь Дундговь аймгийн Аудитын хорооны даргаар томилогдсон тул ТУЗ-ийн гишүүнээс чөлөөлөгдсөн. Төлөөлөн удирдах зөвлөлийн 2018 оны 03 дугаар сарын 09-ны өдрийн хурлаар 2017 оны санхүүгийн тайланг хэлэлцэж, дахин залруулга хийх үүрэг өгч залруулга хийсэн. Санхүүгийн тайланг хавсаргав.

Өнгөрсөн жилүүдэд бид ногдол ашиг хуваарилсан. Бид хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалах хэрэгтэй. Гүйцэтгэх удирдлага, ТУЗ-өөс жил болгон ногдол ашиг хуваарилах хэрэгтэй. Тэр хэмжээгээр хөрөнгийн бирж дээрх манай компанийн үнэлгээ өсдөг. Энэ жил ногдол ашгийг 100 төгрөгөөр хуваарилахаар 2018 оны 03 дугаар сарын 09-ны өдрийн хурлаар шийдвэрлэсэн.

Дараагийн асуудал бол ТУЗ-ийн 2018 оны зардлын төсөв, компанийн үйл ажиллагааны 2018 оны зардлын төсвийн талаар танилцуулав.

Үйлдвэрлэл санхүүгийн төлөвлөгөөг хавсралтаар танилцуулж байна. Үйлдвэрлэлтийг 2,2 тэр бум төгрөг, борлуулалтын орлогыг 2,1 тэрбум төгрөгөөр төлөвлөсөн байна.

Цалинг орон тооны талаар манай компани үндсэн тогтвор суурьшилтай ажиллуулах үүднээс анхаар ажиллаж байна. 2017 онд цалинг 10 хувиар нэмэгдүүлж, баталсан боловч батлагдсан төсвөөр яваагүй бөгөөд энэ жил тэр төсвийг оруулж ирсэн. Та бүхэн санал хүсэлтээ хэлнэ үү.

Бас нэг гол зардал бол Төлөөлөн удирдах зөвлөлийн зардал байдаг энэ зардлыг 108 сая төгрөгөөр санал оруулсан байна.

Дараагийн асуудал бол ТУЗ-ийн гишүүнийг нөхөн сонгох

Компанийн тухай хууль болон компанийн дүрмийн заалтуудыг үндэслэн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг нөхөн сонгох учиртай үүнтэй холбоотойгоор ТУЗ-ийн дарга, Хувьцаа эзэмшигчийн үүднээс төлөөлөн удирдах зөвлөлийн Хараат бус гишүүнд Ц.Жанлавын нэрийг дэвшүүлж байна. Та бүхэнд анкетыг уншиж танилцуулъя.

Цэвэгсүрэн овогтой Жанлав нь 1958 онд төрсөн. Хөргүүрийн инженер мэргэжилтэй, Бизнесийн удирдлагын магистр хүн байна. Дэлгэрэнгүй анкетыг хавсаргав.

4 дүгээр асуудал бол Санхүүгийн тайлангийн талаар аудитын хорооны дүгнэлтийг ТУЗ-ийн хараат бус гишүүн, Аудитын хорооны дарга Д.Нямжав танилцуулна.

Д.Нямжав: Ган хийц ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн хуралд ирсэн хувьцаа эзэмшигчдээ энэ өдрийн мэнд хүргэе. Өнөөдрийн хурал ном дүрмийн дагуу бэлтгэл ажилаа сайн хангаад хийж байна. Хувьцаа эзэмшигчдийн хурлыг хийхийн тулд ТУЗ-ийн гишүүд бид тодорхой хэмжээний бэлтгэл ажил хийсэн, санхүүгийн тайланд шалгалт хийж ажилласан. Миний хувьд ТУЗ-ийн гишүүнээр сонгогдоод анхныхаа Хувьцаа эзэмшигчдийн хуралд сууж байна. Манай аудитын хороонд 3 хүн байдаг. Манай гишүүд олон жил ажилласан туршлагатай, санхүүгийн чиглэлээр мэргэшсэн гишүүд байдаг. Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаар санхүүгийн тайланг танилцуулъя.

“Ган хийц” ХК-н 2017 оны жилийн эцсийн Санхүүгийн тайланг 2017 оны 12 дугаар сарын 31-ны өдрөөр тасалбар болгон тайлагнаж Борлуулалтын орлого 1,6 тэрбум төгрөг, түрээсийн орлого 12,0 сая төгрөг, хүүний орлого 0,1 сая төгрөгийн жилийн орлоготой, борлуулсан бүтээгдэхүүний өртөг 1,2 тэрбум нийт 383,9 сая төгрөгийн үйл ажиллагааны ашигтай ажиллаж 550,4 сая төгрөгийн ерөнхий ба удирдлагын зардал, 4,8 сая төгрөгийн үйл ажиллагааны бус зардалтай нийт 158,9 сая төгрөгийн алдагдалтай ажилласан гэж тайлагнан Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хурлаар танилцуулсан.

2018 оны 03 сарын 14 ний өдрийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хурлын №5 дугаартай тогтоолоор 2017 оны санхүүгийн тайлан баланс алдаатай гарсан тул дахин залруулга хийж холбогдох байгууллагад хүргүүлэх гэсэн шийдвэр гарсны улмаас бид дахин санхүүгийн тайлангаа засварлан та бүгдэд хүргэж байна. /Хавсралтаар танилцуулгыг үзүүлэв. / Анхаарал тавьсан та бүхэнд баярлалаа.

М.Даваасүрэн: Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэх асуудал дууслаа та бүхэн санал хүсэлтээ хэлнэ үү.

Хасуу ХХК-ийн төлөөлөгч Энхмэнд: Хэлэлцсэн асуудал дээр нэмэх санал байхгүй. 2018 оны төсөв дээр нэмэх санал алга байна.

Даваасүрэн: Би Төлөөлөн удирдах зөвлөлийн 2018 оны зардлын төсөвт тусгагдсан.

Би ди сек ҮЦК-ийн төлөөлөгч Тэмүүлэн: 2017 онд ТУЗ-ийн хэлэлцсэн асуудлаас томоохон шийдвэрлэсэн асуудал нь Налайх дүүргийн Аж үйлдвэр технологийн паркард Төмөр замын төмөр бетон дэр, өндөр хүчдлийн тулгуур, сэндвич хавтангийн үйлдвэр, бетон зуурмагийн үзель барихад 11 тэрбум төгрөг шаардлагатай гэж ярилаа та 5 тэрбумыг нь Хөгжлийн банкнаас аваад үлдсэн 6 тэрбумыг нь хувьцаа гаргаж эхлэлтийн хөрөнгө бий болгоно гэж ярьж байна. Нийт төсөл чинь хэчнээн төгрөгийн төсөвт өртөгтэй вэ.

Даваасүрэн: Манай төсөл нийт 32 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй үүнээс эхний ээлжид 11 тэрбум төгрөгийн эхлэлтийн хөрөнгөөр үйлдвэрүүдээ бариад бусад хөрөнгийг үйл ажиллагаанаас гаргаж дараагийн үйлдвэрүүдийг барих төлөвлөгөөтэй байна.

Тэмүүлэн: 2016, 2017 оны борлуулалтын орлого, төмөр хийцийн жин өөр өөр байна. Энэ юунаас болж байгаа вэ.

Даваасүрэн: 2016 онтой харьцуулахад 2017 онд материалын үнэ нэмэгдсэн, манай үйлдвэр бүтээгдэхүүнийхээ үнийг өсгөөгүйгээр ажилласан. Өөр асууж тодруулах зүйл байна уу. Байхгүй бол Тооллогын комисс байгуулъя. Ажилд нь оруулъя. Тооллогын комисст дараах хүмүүсийг сонгох саналтай байна.

Тооллогын комиссын даргаар Б.Ганбат

Гишүүд Л.Чинбат

О.Ууганцэцэг

/100 хувийн саналаар батлав./

Тооллогын комисс бол гурван асуудал дээр санал хураалт явуулна.

1. Компанийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг дүгнэх
2. Төлөөлөн удирдах зөвлөлийн төсөв, компанийн үйл ажиллагааны төсөв
3. Хараат бус гишүүдийг сонгох

Даваасүрэн: Та бүхэнд тарааж өгсөн материал дээр ТУЗ-ийн зардал, Компанийн үйл ажиллагааны зардлын төсвийн харуулсан тул уншиж танилцана уу.

Хурлын дарга М.Даваасүрэн: Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцэх асуудал дууссан тул Тооллогын комисс ажилдаа орж саналын хуудсыг тарааж өгнө үү.

Тооллогын комиссын дарга Б.Ганбат саналын дүн, тооллогын комиссын хурлын протокол, тогтоолыг уншиж танилцуулав. /протокол, тогтоолыг хавсаргав./

Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнээр сонгогдсон Ц.Жанлавд ажлын өндөр амжилт хүсч баяр хүргэе.

Шийдвэрлэсэн нь:

1. Компанийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг ХАНГАЛТТАЙ гэж дүгнэв.
2. 2018 оны ТУЗ-ийн зардлын төсвийг 118 752 000 төгрөгөөр, Компанийн үйл ажиллагааны 2018 оны төсвийг 551 719 560 төгрөгөөр батлав.
3. ТУЗ-ийн хараат бус гишүүнийг нөхөн сонгох асуудлаар хуралд оролцогчийн олонхийн саналаар Хараат бус гишүүнээр Ц.Жанлав нарыг томилов.

Хурлын дарга М.Даваасүрэн хувьцаа эзэмшигчийн саналын дүнг үндэслэн шийдвэрлэсэн асуудалтай холбогдон гарах хурлын тогтоолын төслийг баталж, хурлаас гаргаж буй тогтоолыг уншиж танилцуулснаар хурал өндөрлөв. / тогтоолыг хавсаргав./

Хувьцаа эзэмшигчдийн хурал 2018 оны 04 дүгээр сарын 06 өдрийн 12:50 цагт өндөрлөв.

Хурлын тэмдэглэл хөтөлсөн :

ТУЗ-ийн нарийн бичгийн дарга

О.Ууганцэцэг

Танилцсан:

Хурлын дарга

М.Даваасүрэн

Гишүүн

Б.Эрдэнэбаяр